ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Өргөө амаржих газар” төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2024/22/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

**Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг**
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
**Аудитын менежер: Ц.Хосжаргал**
Утас: 261885 Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn
**Аудитор: М.Пагамдулам**
Утас: 261628 Цахим хаяг: pagamdulamm@audit.gov.mn
**Ингүүмэл жаргалант аудит ХХК-ийн**
**Захирал: Э.Батчимэг**
Утас: 99032916, Цахим хаяг: ij17.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/565

танай ____________-ны № ____________-т

ӨРГӨӨ АМАРЖИХ ГАЗАР ТӨРӨЛЖСӨН
МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ
Д.НАРАНЦАЦРАЛТ
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 166,545.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн, оршин байх, үнэн зөв байдал батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн эцсийн тооллогоор 145,885.8 мянган төгрөгийн дутагдсан тооллогын үр дүнг баталгаажуулаагүй, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, дутагдлыг холбогдох эд хариуцагчаас төлүүлэх арга хэмжээ аваагүй;
- Хэрэгцээ шаардлагыг үндэслэлтэй тооцож нөөц үүсгээгүйгээс 54 нэр төрлийн 153,991.9 мянган төгрөгийн хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгслийг устгаж акталсан, 2023 оны 7 дугаар сард худалдан авсан 1,632.0 мянган төгрөгийн сэтгэцэд нөлөөтэй эм болох кетамины /136 ампул/ хугацаа 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр дууссан;
- Эд хариуцагчийн хариуцаж буй 618,950.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн үлдэгдлийг нягтлан бодогч баталгаажуулаагүй, бараа материалын тайланг батлагдсан маягт, зааврын дагуу бэлтгээгүй;

зэрэг зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4, 72.5.1, 73 дугаар зүйлийн 73.2 заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж,

байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-тай тус тус нийцэхгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант хугацаанд Эрүүл мэндийн даатгалын сангаас 14,365,693.9 мянган төгрөгийн тусламж, үйлчилгээний төлбөр нэхэмжилснээс 14,399,728.8 мянган төгрөгийн санхүүжилт олгогдож, 34,034.9 мянган төгрөгийн санхүүжилтийн тооцоо үүссэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилсэн санхүүжилт бүрэн олгогдоогүйгээс байгууллагуудад олгох 2,112,497.8 мянган төгрөгийн хуримтлагдсан өглөгтэй байна.

**Аудитын гол асуудал**

Засгийн газрын 2021 оны 352 дугаар тогтоолоор эх барих эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор Нийслэлийн Эрүүл мэндийн газрын харьяа Өргөө амаржих газрыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг болгон зохион байгуулж Эрүүл мэндийн яамны эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлсэн боловч Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 460 дугаар тогтоолоор амаржих газар болгон өөрчлөн, Нийслэлийн Засаг даргын харьяанд шилжүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 43 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс хэрэгжилт 82.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2024\0229 SNAG-14.Docx

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,248,222,182.90** | **1,536,055,722.51** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **758,970,864.48** | **241,888,275.92** |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | **758,970,864.48** | **241,888,275.92** |
| **3121** | **Төгрөг** | **758,970,864.48** | **241,888,275.92** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 758,970,864.48 | 241,888,275.92 |
| **33** | **АВЛАГА** | **28,005,105.50** | **14,650,690.54** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 21,147,001.69 | 5,141.73 |
| **335** | **Бусад авлага** | **6,858,103.81** | **14,645,548.81** |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 6,858,103.81 | 14,645,548.81 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **1,461,246,212.92** | **1,279,516,756.05** |
| **351** | **Түүхий эд материал** | **840,337,945.57** | **618,950,873.58** |
| 35130 | Эм боох материал | 840,337,945.57 | 618,950,873.58 |
| **354** | **Хангамжийн материал** | **620,908,267.35** | **660,565,882.47** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,247,660.00 | 3,064,951.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,499,039.00 | 3,270,201.43 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 41,225,295.00 | 34,382,482.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 641,958.39 | 475,431.68 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 555,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 566,294,314.96 | 618,817,316.36 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **21,900,417,571.45** | **20,750,067,401.18** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **21,900,417,571.45** | **20,750,067,401.18** |
| **392** | **Биет хөрөнгө** | **21,456,066,831.45** | **20,305,716,661.18** |
| 39201 | Барилга, байгууламж | 18,917,034,361.30 | 18,917,034,361.30 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,894,556,330.94) | (2,457,961,697.46) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 145,900,000.00 | 145,900,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (93,898,736.31) | (108,048,736.35) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж | 9,492,359,917.18 | 10,094,823,087.48 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (5,874,961,144.76) | (6,973,673,982.66) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 1,216,186,605.38 | 1,244,406,705.38 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (472,387,895.44) | (576,449,231.83) |
| 39213 | Түүх соёлын дурсгалт зүйлс | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 15,145,329.00 | 15,145,329.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,300,865.36) | (6,436,765.08) |

| | | | |
|---|---|---|---|
| 39217 | Номын фонд | 7,545,591.40 | 7,977,591.40 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **444,350,740.00** | **444,350,740.00** |
| 39301 | Программ хангамж | 2,021,500.00 | 2,021,500.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,021,500.00) | (2,021,500.00) |
| | Бусад биет бус хөрөнгө | 444,350,740.00 | 444,350,740.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **24,148,639,754.35** | **22,286,123,123.69** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,626,195,982.52** | **2,334,654,298.58** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,626,195,982.52** | **2,334,654,298.58** |
| **413** | **Өглөг** | **1,626,195,982.52** | **2,300,619,448.58** |
| 4131 | Ажиллагчидтай холбогдсон өглөг | - | 873,223,695.61 |
| 4132 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,599,362,580.52 | 1,335,127,117.97 |
| **4136** | **Бусад өглөг** | **26,833,402.00** | **92,268,635.00** |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 20,092,200.00 | 21,659,480.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 6,741,202.00 | 70,609,155.00 |
| **414** | **Урьдчилж орсон орлого** | | **34,034,850.00** |
| 41420 | Төлбөртэй ажил үйлчилгээний урьдчилж орсон орлого | - | 34,034,850.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **22,522,443,771.83** | **19,951,468,825.11** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **22,522,443,771.83** | **19,951,468,825.11** |
| **511** | **Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан** | **5,619,067,752.19** | **5,619,067,752.19** |
| 51101 | Төрийн өмч | 5,619,067,752.19 | 5,619,067,752.19 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **8,043,233,948.58** | **5,472,259,001.86** |
| 51220 | Өмнөх үеийн үр дүн | 6,333,229,531.59 | 8,043,233,948.58 |
| 51210 | Тайлант үеийн үр дүн | 1,710,004,416.99 | (2,570,974,946.72) |
| **51300** | **Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү** | **8,860,142,071.06** | **8,860,142,071.06** |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **24,148,639,754.35** | **22,286,123,123.69** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **18,368,336,623.16** | **18,152,123,733.89** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,162,762,946.16** | **18,152,123,733.89** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,113,897,519.31** | **3,325,489,251.59** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **2,113,897,519.31** | **3,324,068,874.59** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 706,317,173.00 | 544,137,502.77 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 669,558,905.88 | 2,434,499,728.23 |

| | | | |
|---|---|---|---|
| 1200045 +120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | 738,021,440.43 | 345,431,643.59 |
| **120003** | **Бусад орлого** | **-** | **1,420,377.00** |
| | **Хөрөнгийн орлого** | **3,048,865,426.85** | |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 3,048,865,426.85 | |
| **120017** | **Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө** | **-** | **460,940,532.30** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **13,205,573,677.00** | **14,365,693,950.00** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **13,205,573,677.00** | **14,365,693,950.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,205,573,677.00 | 14,365,693,950.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **16,654,534,264.53** | **20,723,098,680.61** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **16,654,534,264.53** | **20,723,098,680.61** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **16,432,125,537.53** | **20,417,536,845.61** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **8,845,272,969.69** | **11,719,601,549.15** |
| 210101 | Үндсэн цалин | 4,360,420,597.97 | 5,093,846,165.69 |
| 210102 | Нэмэгдэл | 3,484,102,075.00 | 5,373,763,029.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 432,097,000.00 | 704,778,665.49 |
| 210104 | Урамшуулал | 568,653,296.72 | 547,213,688.32 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,134,674,444.06** | **1,488,421,783.88** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 838,383,537.21 | 1,032,615,525.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 79,058,702.34 | 121,340,083.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 60,461,520.77 | 94,842,852.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,225,895.89 | 21,748,678.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 142,544,787.85 | 217,874,644.05 |
| **2103** | **Байр ашиглаттай холбоотой тогтмол зардал** | **491,497,104.32** | **601,184,174.74** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 190,107,632.76 | 249,415,722.01 |
| 210302 | Түлш, халаалт | 103,432,976.56 | 124,220,186.48 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 197,956,495.00 | 227,548,266.25 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **358,150,619.24** | **456,501,690.97** |
| 210401 | Бичиг хэрэг | 56,080,268.00 | 45,515,836.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 10,643,403.83 | 10,400,678.90 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 27,946,219.66 | 45,136,832.72 |
| 210404 | Ном, хэвлэлийн зардал | - | 463,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэдрэгчийн устгал, ариутгал | 177,013,492.00 | 203,836,671.57 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,145,270.00 | 1,569,472.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 85,321,965.75 | 149,579,199.78 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,803,239,309.36** | **4,047,911,645.30** |

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,017,481,809.36 | 3,353,120,645.30 |
| 210502 | Хоол, хүнс | 785,757,500.00 | 694,791,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **93,452,340.00** | **106,689,411.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1.00 |
| 210604 | Урсгал засвар | 93,452,340.00 | 106,689,410.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж** | **141,362,567.02** | **200,834,370.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 108,633,987.00 | 185,483,399.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 16,000,000.00 | 10,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 195,000.00 | 229,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 1,957,200.00 | 33,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,879,500.00 | - |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 3,666,253.02 | 1,462,882.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 8,030,627.00 | 3,625,689.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,564,476,183.84** | **1,796,392,220.57** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 12,468,959.00 | 14,926,780.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 1,552,007,224.84 | 1,781,465,440.57 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **222,408,727.00** | **305,561,835.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **222,408,727.00** | **305,561,835.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 19,698,432.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 215503727.00 | 262,212,702.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,905,000.00 | 23,650,701.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **1,713,802,358.63** | **(2,570,974,946.72)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | **-** | **-** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **3,797,941.64** | **-** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,797,941.64 | - |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | **(3,797,941.64)** | **-** |
| **7** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **1,710,004,416.99** | **(2,570,974,946.72)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* *\/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **15,209,930,375.39** | **17,397,270,614.00** |
| **I.I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,356,675,002.39** | **2,997,541,814.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,356,675,002.39** | **2,997,541,814.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,356,675,002.39** | **2,997,541,814.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 706,388,723.00 | 544,137,502.77 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 646,916,377.05 | 2,451,983,934.23 |
| 140020 | Бусад орлого | 3,369,902.34 | 1,420,377.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **13,853,255,373.00** | **14,399,728,800.00** |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **13,853,255,373.00** | **14,399,728,800.00** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,853,255,373.00 | 14,399,728,800.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **14,416,467,757.74** | **17,851,090,464.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **14,416,467,757.74** | **17,851,090,464.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **14,173,506,324.74** | **17,546,457,061.56** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **8,924,785,477.41** | **11,279,351,310.98** |
| 210101 | Үндсэн цалин | 4,605,771,400.48 | 4,691,572,177.96 |
| 210102 | Нэмэгдэл | 3,393,568,844.22 | 5,322,535,132.10 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 355,552,830.09 | 712,037,606.01 |
| 210104 | Урамшуулал | 569,892,402.62 | 553,206,394.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,056,663,367.08** | **1,055,512,374.48** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 757,913,073.02 | 716,479,404.95 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 79,642,513.76 | 88,953,026.99 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 60,667,127.55 | 68,807,281.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 14,318,715.09 | 16,420,207.37 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 144,121,937.66 | 164,852,454.00 |
| **2103** | **Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал** | **471,416,114.58** | **621,508,439.21** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 169,783,368.29 | 269,739,986.48 |
| 210302 | Түлш, халаалт | 103,432,977.29 | 124,220,186.48 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 198,199,769.00 | 227,548,266.25 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **260,489,827.41** | **269,188,378.22** |
| 210401 | Бичиг хэрэг | 48,451,101.00 | 47,030,026.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,283,900.00 | 8,604,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 27,946,221.41 | 44,741,850.22 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 561,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 162,045,151.00 | 155,968,240.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,763,454.00 | 12,282,962.00 |
| **2105** | **Норматив зардал** | **3,193,323,640.26** | **4,044,414,634.67** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,375,084,640.26 | 3,402,043,334.67 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 796,898,000.00 | 631,063,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 21,341,000.00 | 11,308,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **122,470,090.00** | **126,368,941.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,211,300.00 | 7,010,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,735,960.00 | 12,744,501.00 |
| 210604 | Урсгал засвар | 99,522,830.00 | 106,614,440.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **133,771,608.00** | **131,797,783.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 104,975,223.00 | 113,919,101.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 16,000,000.00 | 10,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,891,200.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 195,000.00 | 229,400.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 33,000.00 | 33,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 2,879,500.00 | - |
| 210808 | Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 10,000.00 | 1,462,882.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 7,787,685.00 | 6,153,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **10,586,200.00** | **18,315,200.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,586,200.00 | 18,315,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **242,961,433.00** | **304,633,403.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **242,961,433.00** | **304,633,403.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | 19,698,432.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 235,516,433.00 | 262,212,702.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7,445,000.00 | 22,722,269.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **793,462,617.65** | **(453,819,850.56)** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **55,470,300.00** | **63,262,738.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **55,470,300.00** | **63,262,738.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **55,470,300.00** | **63,262,738.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 55,470,300.00 | 63,262,738.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(55,470,300.00)** | **(63,262,738.00)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **737,992,317.65** | **(517,082,588.56)** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 20,978,546.83 | 758,970,864.48 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 758,970,864.48 | 241,888,275.92 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **5,619,067,752.19** | **8,860,142,071.06** | **6,333,229,531.59** | **20,812,439,354.84** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | | - |
| **Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл** | **5,619,067,752.19** | **8,860,142,071.06** | **6,333,229,531.59** | **20,812,439,354.84** |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 1,710,004,416.99 | 1,710,004,416.99 |
| **2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **5,619,067,752.19** | **8,860,142,071.06** | **8,043,233,948.58** | **22,522,443,771.83** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | - |
| **Дахин илэрхийлэгдсэн үлдэгдэл** | **5,619,067,752.19** | **8,860,142,071.06** | **8,043,233,948.58** | **22,522,443,771.83** |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | (2,570,974,946.72) | (2,570,974,946.72) |
| **2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **5,619,067,752.19** | **8,860,142,071.06** | **5,472,259,001.86** | **19,951,468,825.11** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **18,724,964,100.00** | **17,914,353,202.56** | **810,630,897.44** | **95.7** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **18,724,964,100.00** | **17,914,353,202.56** | **810,630,897.44** | **95.7** |
| **210** | **Бараа, үйлчилгээний зардал** | **18,051,665,600.00** | **17,609,719,799.56** | **441,945,800.44** | **97.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **11,340,881,300.00** | **11,279,351,310.98** | **61,529,989.02** | **99.5** |
| 210101 | Үндсэн цалин | 5,684,951,300.00 | 4,691,572,177.96 | 993,379,122.04 | 82.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 4,446,419,600.00 | 5,322,535,132.10 | (876,115,532.10) | 119.7 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 717,918,600.00 | 712,037,606.01 | 5,880,993.99 | 99.2 |
| 210104 | Урамшуулал | 491,591,800.00 | 553,206,394.91 | (61,614,594.91) | 112.5 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **1,797,862,700.00** | **1,055,512,374.48** | **742,350,325.52** | **58.7** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 1,366,783,100.00 | 716,479,404.95 | 650,303,695.05 | 52.4 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 122,304,800.00 | 88,953,026.99 | 33,351,773.01 | 72.7 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 71,838,400.00 | 68,807,281.17 | 3,031,118.83 | 95.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 21,748,400.00 | 16,420,207.37 | 5,328,192.63 | 75.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 215,188,000.00 | 164,852,454.00 | 50,335,546.00 | 76.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **645,213,600.00** | **621,508,439.21** | **23,705,160.79** | **96.3** |
| 210301 | Гэрэл цахилгаан | 276,286,600.00 | 269,739,986.48 | 6,546,613.52 | 97.6 |
| 210302 | Түлш, халаалт | 130,086,000.00 | 124,220,186.48 | 5,865,813.52 | 95.5 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 238,841,000.00 | 227,548,266.25 | 11,292,733.75 | 95.3 |
| 210304 | Байрны түрээс | - | - | - | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **267,369,500.00** | **269,320,378.22** | **(1,950,878.22)** | **100.7** |
| 210401 | Бичиг хэрэг | 47,103,900.00 | 47,030,026.00 | 73,874.00 | 99.8 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 6,528,800.00 | 8,604,000.00 | (2,075,200.00) | 131.8 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 44,742,500.00 | 44,741,850.22 | 649.78 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 693,300.00 | 693,300.00 | - | 100.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэдрэгчийн устгал, ариутгал | 156,064,700.00 | 155,968,240.00 | 96,460.00 | 99.9 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,236,300.00 | 12,282,962.00 | (46,662.00) | 100.4 |
| **2105** | **Нормативт зардал** | **3,684,659,500.00** | **4,044,414,634.67** | **359,755,134.67** | **109.8** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,993,351,200.00 | 3,402,043,334.67 | 408,692,134.67 | 113.7 |
| 210502 | Хоол, хүнс | 680,000,000.00 | 631,063,000.00 | 48,937,000.00 | 92.8 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 11,308,300.00 | 11,308,300.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил худалдан авах** | **162,848,600.00** | **189,199,679.00** | **(26,351,079.00)** | **116.2** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 29,006,700.00 | 43,821,338.00 | (14,814,638.00) | 151.1 |
| 210602 | Тавилга | 26,019,400.00 | 26,019,400.00 | - | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 13,845,600.0 | 12,744,501.00 | 1,101,099.00 | 92.0 |
| 210604 | Урсгал засвар | 93,976,900.00 | 106,614,440.00 | (12,637,540.00) | 113.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **140,881,400.00** | **131,797,783.00** | **9,083,617.00** | **93.6** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 120,051,200.00 | 113,919,101.00 | 6,132,099.00 | 94.9 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 10,000,000.00 | 10,000,000.00 | - | 100.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 229,400.00 | 229,400.00 | - | 100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 33,000.00 | 33,000.00 | - | 100.0 |
| 210807 | Газрын төлбөр | 2,879,500.00 | - | 2,879,500.00 | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 1,500,000.00 | 1,462,882.00 | 37,118.00 | 97.5 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 6,188,300.00 | 6,153,400.00 | 34,900.00 | 99.4 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,949,000.00** | **18,615,200.00** | **(6,666,200.00)** | **155.8** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,949,000.00 | 18,615,200.00 | (6,666,200.00) | 155.8 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **673,318,500.00** | **304,633,403.00** | **368,685,097.00** | **45.2** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 32,894,000.00 | 19,698,432.00 | 13,195,568.00 | 59.9 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох бусад тэтгэмж, урамшуулал | 591,974,500.00 | 262,212,702.00 | 329,761,798.00 | 44.3 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 48,450,000.00 | 22,722,269.00 | 25,727,731.00 | 46.9 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **18,724,984,100.00** | **17,914,353,202.56** | **810,630,897.44** | **95.7** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **122** | **ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ** | **13,945,536,100.00** | **14,399,728,800.00** | **(454,192,700.00)** | **103,3** |
| 122001 | ЭМД-ийн санхүүжилт | 13,945,536,100.00 | 14,399,728,800.00 | (454,192,700.00) | 103.3 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **4,779,448,000.00** | **3,514,624,402.56** | **1,264,823,597.44** | **73.5** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,104,528,600.00 | 544,137,502.77 | 560,391,097.23 | 49.3 |
| 120042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,918,378,000.00 | 2,453,404,311.23 | 464,973,688.77 | 84.0 |
| 120043 | Урд оны үлдэгдлээс санхүүжих | 756,541,400.00 | 517,082,588.56 | 239,458,811.44 | 68.3 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 758,970,864.48 | - | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 241,888,275.92 | - | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **1** | **100.0** |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **487** | **341** | **146** | **70.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 7 | 1 | **6** | 14.3 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 344 | 180 | **164** | 52.3 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 136 | 160 | **(24)** | 117.6 |

## 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 4,491,453.9 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 2,199,977.4 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 2,291,476.5 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 3,428,679.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.

Аудитаар нийт 4,491,453.9 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 2,199,977.4 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 2,291,476.5 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж хүргүүлсэн.

/мянган төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">Зөрчлийн товч утга</th><th colspan="2" rowspan="2">Нийт зөрчил</th><th colspan="10">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th><th colspan="2">Хариуцлага тооцуулах албан шаардлага</th><th colspan="2">Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Албан тушаалтны тоо</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td>Хэрэгцээ шаардлагыг үндэслэлтэй тооцож нөөц үүсгээгүйгээс 54 нэр төрлийн 153,991.9 мянган төгрөгийн хугацаа дууссан эм, эмнэлгийн хэрэгсэл устгаж акталсан, 2023 оны 7 дугаар сард худалдан авсан 1,632.0 мянган төгрөгийн 136 ампул сэтгэцэд нөлөөтэй эм болох кетамины хугацаа 2024 оны 1 дүгээр</td><td>1</td><td>155,623.9</td><td></td><td></td><td>1</td><td>155,623.90</td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| сарын 1-ний өдөр дууссан байна. | | | | | | | | | | | | |
| Эд хариуцагч бараа материалын тайлан /НХМаягт БМ-9/-г батлагдсан маягт, зааврын дагуу гаргадаггүй, эд хариуцагчийн бараа материалын үлдэгдлийг нягтлан бодогч баталгаажуулаагүй байна. | 1 | 618,950.9 | | | 1 | 618,950.90 | | | | | | |
| Тус газарт ашиглагдаж байсан 2 нэр төрлийн 124 ширхэг, 76,265.9 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр Ховд, Сүхбаатар, Баян-Өлгий аймгуудын нэгдсэн эмнэлэгт шилжүүлсэн байна. | 1 | 76,265.9 | - | - | | | 1 | 76,265.9 | - | - | - | - |
| 2018 оны тооллогоор 6 нэр төрлийн 16,535.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж дутагдсан асуудлыг Сүхбаатар дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтэст гомдол гарган шалгуулж байгаа | 1 | 16,535.7 | | | | | 1 | 16,535.7 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| боловч өнөөдрийг хүртэл шийдвэрлэгдээгүй, үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байна | | | | | | | | | | | | |
| Тооллогын бүртгэлд тооллогын комисс гарын үсэг зурж баталгаажуулаагүй, тооллогын үр дүн /илүүдэл, дутагдал/-г тооцож гаргасан баримт байхгүй, тооллогын комисс тооллогын тооцоо бодсон акт үйлдээгүй, эд хариуцагчаар баталгаажуулаагүй, тооллогын баримтыг нягтлан бодогчид хүлээлгэн өгсөн баримт байхгүй байна. Мөн тооллого эхлэхийн өмнө эд хариуцагчаас эд хөрөнгийн орлого, зарлагын бүх баримтыг нягтлан бодогчид бүрэн шилжүүлсэн эсэх тухай баталгааг гаргуулан авдаггүй байна. | 1 | 1,279,516.8 | | | 1 | 1,279,516.8 | | | | | | |
| Эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн эцсийн тооллогоор 145,885.8 мянган төгрөгийн дутагдал | 1 | 145,885.8 | | | 1 | 145,885.8 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| гарсан боловч тооллогын үр дүнг баталгаажуулаагүй нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, хологдох эд хариуцагчаар төлүүлэх арга хэмжээ аваагүй байна. | | | | | | | | | | | | |
| Өвчтөний түүхийн баримтын бүрдүүлэлтэд тавих хяналт хангалтгүйгээс ЭМДС-аас нэхэмжилсэн гүйцэтгэлийн санхүүжилтээ бүрэн авч чадаагүй байна. | 1 | 1,062,774.9 | | | | | 1 | 1,062,774.9 | | | | |
| 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг хэрэгцээ шаардлагад нийцүүлэн үндэслэлтэй боловсруулаагүйгээс 1,135,000.0 мянган төгрөгийн оношилгооны уян дуран худалдан авах тендер зарлан, шалгаруулалт явуулж гэрээ байгуулсан боловч тоног төхөөрөмж худалдан авах | 1 | 1,135,000.0 | | | | | 1 | 1,135,000.0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ажлыг зогсоосон байна. | | | | | | | | | | | | |
| Тус байгууллагын гүйцэтгэх захирлын 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн А/63 дугаар тушаалаар баталсан НБББББ нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцсэн боловч байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна. | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| 2023.02.01-ны өдрийн худалдан авалтын 900.0 мянган төгрөгийн төлбөрийг И баримтаар баталгаажуулаагүй байна. | 1 | 900.0 | | | | | 1 | 900.0 | | | | |
| **Дүн** | **10** | **4,491,453.9** | **-** | **-** | **4** | **2,199,977.4** | **6** | **2,291,476.5** | **-** | **-** | **-** | **-** |

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, хугацаанд нь мэдээлээгүй болон бусад холбогдох хууль, дүрэм журам зөрчсөн 10,997,764.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 албан шаардлага, 6 зөвлөмж өгсөн.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 13 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Шилэн дансны системд мэдээлэх ёстой 890,461.6 мянган төгрөгийн дүн бүхий 48 мэдээллийг мэдээлээгүй, 10,107,302.7 мянган төгрөгийн дүн бүхий 183 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна | 1 | 10,997,764.3 | | | 1 | 10,997,764.3 | | |
| **Дүн** | **1** | **10,997,764.3** | **-** | **-** | **1** | **10,997,764.3** | **-** | **-** |
| **Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил** | | | | | | | | |
| Ээлжийн амралт олгох тухай мэдэгдлийг батлагдсан маягтын дагуу хөтөлдөггүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| МУ-ын Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 460 дугаар тогтоолоор тус эмнэлэгийг үйл ажиллагаа, чиг үүргийн хувьд амаржих газар болгон өөрчлөн зохион байгуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяалалд ажиллуулахаар шийдвэрлэсэн байна. Гэвч тухайн байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, дүрэмд өөрчлөлтийг оруулж улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Байгууллагын бүтэц зохион байгуулалтаар батлагдсан зарим ажил, албан тушаалын ажлын байрны тодорхойлолт байхгүй байна. Тухайлбал: Хүний нөөцийн мэргэжилтэн, эм зүйн албаны дарга, нярав, эд хариуцагч нарын ажлын байрны тодорхойлолт байхгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдлыг хариуцсан ажилтнуудтай эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээ байгуулаагүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| Эрүүл мэндийн сайдын 2023 оны 1а/3139 дүгээр албан бичгээр ирсэн чиглэлийн дагуу илүү цагийн хөлс тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлсийг оруулахгүй байхаар шийдвэрлэсэн боловч нийт ажилтан, албан хаагчдад албан ёсоор танилцуулаагүй байна. | 1 | | | | | | 1 | - |
| Сарын эцэст ажилтны ажилласан цагийн тооцоог батлагдсан маягт, зааврын дагуу нэгтгэн гаргадаггүй байна. | 1 | | | | | | 1 | |
| **Дүн** | **6** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **6** | **-** |
| **Нийт дүн** | **7** | **10,997,764.3** | **-** | **-** | **1** | **10,997,764.3** | **6** | **-** |